



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 04 сарын 09 өдөр

Дугаар А/165

Мөрөн сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, 41.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.8, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 2.1.4, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2024 оны 10, 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Оросын Холбооны улсаас хүмүүнлэгийн тусламжаар ирсэн 100 тн тэжээлийн будаа (овьёос) Сэлэнгэ аймгаас татан авах тээврийн зардал, цаг агаар дулаарч шар усны үерийн болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажилд зориулж сумдад олгох хөрөнгийн задаргааг хавсралтаар баталсугай.

2.Тэжээлийн будаа татах тээврийн зардал, шар усны үерийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх зардалд шаардагдах нийт 25,000,000 (Хорин таван сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Б.Батбилгүүн)-т зөвшөөрсүгэй.

3.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Оюунтуяа)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны
04 дугаар сарын 09-ны өдрийн 4/5 дугаар
захирамжийн хавсралт

НӨӨЦ ХӨРӨНГӨӨС ЗАРЦУУЛАХ ЗАРДЛЫН ТООЦОО

№	Байгууллагын нэр	Зардлын утга	Хөрөнгийн хэмжээ
1	Тээврийн зардал	Сэлэнгэ аймгаас тэжээлийн будаа татах зардал	12,000,000
2	Баянзүрх сум	Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх	3,000,000
3	Рэнчинлхүмбэ сум	Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх	3,000,000
4	Галт сум	Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх	3,500,000
5	Цэцэрлэг сум	Шар усны үерийн аюулаас урьдчилан сэргийлэх	3,500,000
	Бүгд		25,000,000

-----oOo-----